

ТЭМДЭГЛЭЛТ ОЙ, МЭДЭЭЛЭЛ

**БҮХ ХЯТАДЫН АРДЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЗУРГАА ДАХЬ УДААГИЙН СОНГУУЛИЙН
ГУРАВДУГААР ЧУУЛГАНЫ ТУХАЙ**
(Товч мэдээ)

БХАТХ-ын зургаа дахь удаагийн сонгуулийн гуравдугаар чуулган 1985 оны 3-р сарын 27-ноос 4-р сарын 10-нд Бээжинд болов.

Чуулганы БХАТХ-ын Байнгын Хорооны дарга Пэн Жэнь нээв. Чуулганд засгийн газрын ажлын тухай илтгэлийг БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жао Зыян, Улс ардын аж ахуй, нийгмийг хөгжүүлэх 1985 оны төлөвлөгөөний төслийн тухай илтгэлийг БНХАУ-ын Төлөвлөгөөний Комиссын дарга Сун Пин, 1984 оны улсын төсвийн гүйцэтгэл, 1985 оны улсын төсвийн төслийн тухай илтгэлийг БНХАУ-ын Сангийн Яамны сайд Ван Биньцянь, БХАТХ-ын Байнгын Хорооны ажлын тухай илтгэлийг БХАТХ-ын Байнгын Хорооны орлогч дарга Чэнь Писян, Ардын дээд Шүүхийн ажлын тухай илтгэлийг БНХАУ-ын Ардын дээд Шүүхийн дарга Чжэн Тяньсянь, Ардын дээд Прокурорын Газрын ажлын тухай илтгэлийг БНХАУ-ын Ардын дээд Прокурорын Газрын ерөнхий прокурор Ян Ичэнь нар тавив. Чуулганы нээлтийн ажиллагаанд ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ху Яобан, БНХАУ-ын дарга Ли Сяньнянь, орлогч дарга Улаанхүү, Бүх хятадын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн дарга Дэн Инчао нар, хаалтын ажиллагаанд Ли Сяньнянь, Жао Зыян, Дэн Инчао, Улаанхүү нар оролцов.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жао Зыян засгийн газрын ажлын тухай “Эдийн засгийн одоогийн байдал ба аж ахуйн системийн шинэтгэл” гэсэн илтгэлдээ хятадын дотоод эдийн засгийн хөгжлийн асуудлаар голлон ярьж, гадаад бодлогын талаар бараг юу ч ярьсангүй. Гэхдээ, Хятадын гадаад бодлогын талаар Жао Зыяны тавьсан илтгэлийн эхэнд орсон цорын ганц өгүүлбэрээс үзэхэд 1984 онд Хятадын удирдлага “биеэ даасан” гадаад бодлогыг явуулж “жанжлалын эсрэг” тэмцсэн хэвээр байжээ.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд илтгэлдээ “нэг улс дахь хоёр систем”-ийн бодлогыг хэрэгжүүлэн, Гонконгийн асуудлыг амжилттай шийдвэрлэсэн явдал Тайванийг эх оронтойгоо нэгтгэх үйлсэд “чухал түлхэц” болно гэж тэмдэглэжээ.

Жао Зыян илтгэлдээ Хятадын эдийн засгийн хөгжлийн ерөнхий байдал сайн, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт түргэн хурдацтай байгааг, тухайлбал, 1984 онд аж үйлдвэр, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн нэг триллион юаньд хүрч, хүнд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 14,2%-иар, хөнгөн үйлдвэрийн нийт

бүтээгдэхүүн 13,9%-иар, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн 14,5%-мах тус тус нэмэгдэж, 1984 онд 770 гаруй сая тонн нүүрс, 114 гаруй сая тонн нефть, 407 гаруй сая тонн үр тариа, 6,08 сая тонн хөвөн тус тус үйлдвэрлэсэн болон ард түмний амьдралын түвшин дээшилснийг, тухайлбал, 1984 онд хотын хүн амын дундаж орлого 608 юань, хөдөөгийн тариачдын дундаж орлого 355 юаньд тус тус хүрч, Хятадын хүн ам бүрт 400 орчим кг үр тариа, 5 гаруй кг хөвөн тус тус ноогдох болсныг тэмдэглэхийн зэрэгцээ Хятадын улс ардын аж ахуйг хөгжүүлэхэд багагүй бэрхшээл оршиж байгааг хүлээн зөвшөөрчээ. Төр, Хятадын улс ардын аж ахуйд эрчим хүч, тээвэр, харилцаа холбоо, түүхийн эдээр дутагдаж байгаагаас гадна өнгөрсөн оны сүүлийн хагаст Хятадад цаасан мөнгийг хэмжээнээс хэтрүүлэн гаргаж, зарим барааны үнэ нэмэгдсэнийг тэмдэглэжээ. Хятадын санхүү, эдийн засгийн байдал хүнд хэвээр байгааг 1984 онд хятадын санхүүгийн нийт орлого нь 146,5 миллиард юань, зарлага нь 151,5 миллиард юань байсан буюу орлогоос давсан зарлагын хэмжээ нь 5 миллиард юаньд хүрсэн явдал харуулж байна. (1983 онд Хятадын санхүүгийн орлогоос давсан зарлагын хэмжээ нь 4,346 миллиард юань байжээ.)

Засгийн газрын ажлын тухай БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын тавьсан илтгэлээс үзэхэд Хятадын удирдлага “нээлттэй хаалга”-ын бодлогыг хэрэгжүүлсэн хэвээр байна. Тухайлбал, 1984 онд Хятадаас гадаад орнуудтай хамтран бүгд 741 үйлдвэрийн газрыг байгуулах болсон нь өнгөрсөн таван жилийн нийт хэмжээнээс давсан бөгөөд 1984 онд Хятадын хэмжээгээр янз бүрийн хэлбэрээр ашиглагдсан гадаадын хөрөнгийн хэмжээ нь 2,66 миллиард ам.долларт хүрсэн нь 1983 оныхоос 35,7%-иар нэмэгдэв гэж засгийн газрын ажлын тухай илтгэлд дурджээ.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жао Зыян илтгэлийнхээ төгсгөлд “аж ахуйн системд хийх шинэтгэл”-ийг цаашид үргэлжлүүлэн явуулахыг заагаад ХКН-ын 11 дэх удаагийн сонгуулийн III (1978 оны) бүгд хурлаас хойших чиг шугамыг хатуу баримтлан, Хятадын олон үндэстний ард түмний шаргуу хөдөлмөрөөр “дөрвөн шинэчлэлт”-ийн зорилтыг биелүүлж чадна гэж тэмдэглэжээ.

Чуулганаар “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын засгийн газар, Их Британи ба Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын засгийн газрын хооронд Гонконгийн асуудлаар хамтран гаргасан тунхаглал”, “БНХАУ-ын Гонконгийн засаг захиргааны тусгай районы Үндсэн хуулийг боловсруулах комиссыг байгуулах тухай шийдвэр”, “Аж ахуйн системд шинэтгэл хийх болон гадаад орнуудтай чөлөөтэй харилцах талаар түр мөрдөж дагаж хууль дүрмийг боловсруулан гаргах эрхийг Төрийн Зөвлөлд олгох тухай шийдвэр”, “БНХАУ-ын өв залгамжлах хууль” зэрэг баримт бичгийг хэлэлцэн батлав.

Н.Батаа